



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 11 сарын 14 өдөр


Дугаар 255


Мандалговь

**Хөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Аймгийн Цагдаагийн хэлтэст “Тогтвортой амьжиргаа-2” төсөлд ашиглагдаж байсан 1'738'306 /нэг сая долоон зуун гучин найман мянга гурван зуун зургаа/ төгрөгийн анхны өртөгтэй 278'573 /хочр зуун далан найман мянга таван зуун далан гурав/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий тоног төхөөрөмжийг хавсралтын дагуу балансаас баланст шилжүүлэн авахыг зөвшөөрсүгэй.
2. Эд хөрөнгийг зохих журмын дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Цагдаагийн хэлтсийн дарга Л.Гүндсүрэнд даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга П.Очирбатад үүрэг болгосугай.

ДАРГА  С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 11 сарын 14 өдрийн ...-р тогтоолын хавсралт

Шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Нэр	Хэмжих нэгж	Тоо	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Зөврийн компьютер	ш	2	2010.05.01	779,153.0	1,558,306.0	1,395,982.6	162,323.4
2	Принтер Samsung	ш	2	2011.02.28	90,000.0	180,000.0	63,750.0	116,250.0
ДҮН						1,738,306.0	1,459,732.6	278,573.4

